



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/103

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, сумын Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 42 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд ажиллаж байгаа албан хаагчдад шаардлагатай дархлааг дэмжих бүтээгдэхүүн, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, шатахуун, цар тахлын халдвараар өвчлөн Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлэгсдийн хоолны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Холбогдох арга хэмжээнд шаардагдах 5000000 /таван сая/ төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Шивээ Овоо хувьцаат компаниас хандивласан сумын Онцгой комиссын хөрөнгөнөөс зориулалтын дагуу зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2021 оны 06-р сарын 30-ны өдрийн 110 дугаар захирамжийн хавсралт



Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад шаардлагатай зардлын тооцоо

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун	АИ-92, 975.6 л	1,560	1,522,000
2	Хоол хүнс, витамин	20	100,000	2,000,000
3	Цахилгаан	2	200,000	400,000
4	Тогоочийн зардал	2	389,000	778,000
5	Бичгийн цаас	23	11,000	253,000
6	Принтерийн хор	1	47,000	47,000
<b>Нийт дүн</b>				<b>5,000,000</b>